

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН БИД:

Албаны эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, хуульд нийцсэн тушаал, шийдвэрийг ёсчлон биелүүлэх зарчмыг удирдлага болгоно.

Олон нийттэй мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэн, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцан, ажил үүргийн харилцаандаа бусдад хүндэтгэл төрүүлэхүйц байхыг эрмэлзэнэ.

АНХААРАХ



ЧИГЧ ШУДАРГА, ЗАРЧИМЧ БАЙХ

Төрийн аудитын үйл ажиллагааг хуульд нийцүүлэн, нийтийн эрх ашгийн төлөө бие даан гүйцэтгэж, хуулиар олгосон бүрэн эрхийг өргөсөн тангарагтаа үнэнч, чигч шударгаар хэрэгжүүлэх үүрэгтэй



АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС АНГИД БАЙХ

Шалгагдагч байгууллага, аудитад хамрагдагч болон тэдгээрийн хамаарал бүхий бусад этгээдтэй хувийн харилцаа тогтоох, шууд болон шууд бусаар тусламж авах, хувьдаа ашиг олох, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгээр үйлчлүүлэх, дайлуулах, хууль бус хангамж эдлэх зэргээр албан тушаалын нэр хүндийг ашиглан ямар нэгэн давуу байдал бий болгож болохгүй



НУУЦЫГ ЗАДРУУЛАХГҮЙ БАЙХ

Албаны үүргээ хэрэгжүүлэх явцдаа олж мэдсэн болон өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулах, эсхүл өөр зорилгоор ашиглаж болохгүй



АЛБАНЫ НЭР ХҮНДИЙГ ЭРХЭМЛЭХ

- Удирдах, удирдуулах ёсыг мөрдөж, нөхөрсөг, шударга, ажил хэрэгч харилцааг эрхэмлэнэ
- Өөрийн эргэн тойронд ёс зүйн эрүүл орчныг бүрдүүлнэ
- Ялгаварлан гадуурхах, басамжлах, нэр төрийг нь гутаан доромжилж, дарамт шахалт үзүүлэх, чирэгдүүлэх, хүнд суртал гаргах, түүнтэй адилтгах санаатай үйлдэл гаргахгүй
- Албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

ХОРИГЛОХ



АЛБАН ҮҮРГЭЭС БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Холбогдох хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд үндсэн албан тушаалаас гадна давхар албан тушаал хаших, зар сурталчилгаанд оролцох, ажлын байр, техник, тоног төхөөрөмж, санхүү, мэдээллийн хэрэгслийг хувийн зорилгоор дур мэдэн ашиглахгүй байх



УЛС ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ХЯЗГААРЛАЛТ

Улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх



БЭЛЭГ, ЗЭЭЛ, ӨВ ХӨРӨНГӨ, ҮЙЛЧИЛГЭЭ ХҮЛЭЭНАВАХ ХЯЗГААРЛАЛТ

Албан үүргээ биелүүлсэн болон биелүүлээгүйн төлөө өөрөө эсхүл өөрийн хамаарал бүхий этгээдээр дамжуулан бусдаас төлбөр, бэлэг, зээл өв хөрөнгө, хандив, үйлчилгээ, урамшуулал бусад үнэ бүхий зүйл авахгүй байх



ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ

- Аудит гүйцэтгэх явцад олж авсан бүрэн бус мэдээлэлд тулгуурлан урьдчилсан дүгнэлт хийж, хувь хүн, байгууллагын нэр хүндэд халдах, эсхүл олон нийтэд мэдээлж болохгүй
- Аудитын албан ёсны шийдвэр, бусад ажилтны мэргэшлийн үйл ажиллагааны талаар эргэлзээ төрүүлэхүйц ойлголтыг олон нийтэд мэдээлж болохгүй
- Олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ ашиглахдаа байгууллага, албаны нэр хүндэд харшилсан, эсхүл аудитын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх санал, сэтгэгдэл, зураг, дуу, дүрс бичлэг болон бусад хэлбэрийн мэдээ, мэдээлэл байршуулахгүй

ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛ